

УЛАМЖЛАЛТ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛЧИД ШИНЭ ЦАГ
ҮЕТЭЙ ХЭРХЭН ЗОХИЦОХ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Цэлмэг (БНХАУ)*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: сүлжээний хэвлэл мэдээлэл, уламжлалт хэвлэл мэдээлэл, мэдээллийн урсгал, мэдээ зангийн тавцан, тоон телевиз.

Сүлжээний хэвлэл мэдээлэл, хувийн хэвлэл мэдээлэл, дижитал хэвлэл мэдээлэл зэрэг шинэ маягийн хэвлэл мэдээллүүд бий болохыг дагалдан уламжлалт хэвлэл мэдээллийн давуу тал нь багагүй саад бэрхшээлтэй тулгарч, эдгээр “шинэ хэвлэл мэдээлэл” хэмээх хэвлэл мэдээллүүд нь өөрийн түргэн шуурхай, дөхөм тод давуу талаараа маш ахар богино хугацаанд бүх хэвлэл мэдээллийн талаас илүү хувийг эзлэх болжээ.

Холбогдол бүхий бүртгэлээс үзэхэд 2021 оны 12 дугаар сарын байдлаар Дундад улсын сүлжээний иргэдийн тоо 10.32 дүншүүр болж, интернэт сүлжээний түгээмэлжсэн үзүүлэлт нь 73.0% , гар утсаар сүлжээнд орох үзүүлэлт нь 99.7%-д хүрчээ. Гол болох гар утасны АРР том мэдээ зангийн тавцан нэгэнт улсын дотоодын 90%-ээс дээших сүлжээн дээр гүйлгэн үзэх хэмжээг татаж, Дундад улсын үй олон сүлжээнд гол байр эзлэх болжээ (Интер сүлжээний төв, 2022). Гар утсаар мэдээ занги олох шинэ маягийн хэвлэл мэдээлэл эрчимтэй хөгжиж, Дундад улсын хэвлэл

мэдээллийн гол урсгалыг хөтлөн дагуулж, нийгмийн халамшил асуудлын хэрэг явдалд яриа хэлэлцээний давалгаан үүсгэх үйлдэл үзүүлж байна. Иймээс уламжлалт хэвлэл мэдээлэл нь их орчин тойрны хувиралтын урсгалд өөрийгөө хэрхэн зохицуулах явдал тулгамдсан асуудлын нэг болж байна.

Шинэ, хуучин хэвлэл мэдээллийн онцлог шинж: Уламжлалт хэвлэл мэдээлэлтэй харьцуулахад шинэ хэвлэл мэдээлэл нь сонин сэтгүүл, радио нэвтрүүлэг, телевиз зэрэг уламжлалт хэвлэл мэдээллээс хожим хөгжиж ирсэн юм. Шинэ хэвлэл мэдээллийн хэлбэрт сүлжээний хэвлэл мэдээлэл, гар утасны хэвлэл мэдээлэл болон тоон телевиз багтана. Америкийн “Холбоос” сэтгүүлд шинэ хэвлэл мэдээлэл бол бүх хүмүүс нь бүх хүмүүст мэдээ занги уламжилна гэжээ. НҮБ-ын Соёл, боловсрол, шинжлэх ухааны байгууллагаас (ЮНЕСКО) шинэ хэвлэл мэдээллийг “тооны мэргэжлээр суурь болгож, сүлжээгээр ачаалбар болгон мэдээ занги дамжуулах зууч” (Дуван, 2019) гэж томъёолжээ. Уламжлалт хэвлэл мэдээлэлтэй харьцуулбал шинэ хэвлэл мэдээллийн давуу тал бол хамтаар эдлэх чанар ба түргэн шуурхай чанар юм. Иймээс уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлч нь шинэ хэвлэл мэдээллийн

эдгээр давуу талыг идэвхтэйгээр ашиглаж, өөрийн давуу талаа бүтээлчээр хэрэгжүүлэх нь чухал юм.

Уламжлалт хэвлэл мэдээллийн давуу тал нь түүний орлуулж болшгүй баялаг агуулгад нь бий. Шинэ хэвлэл мэдээлэлтэй адилтгавал уламжлалт хэвлэл мэдээлэл нь мэдээ занги нийтлэх эрх сүрт чанар, чанга нямбай чанар, үнэн бодит чанар зэрэг онцлогтой байдаг. Олон жилийн хөгжил болон туршлагаар дамжаад сонин сэтгүүл, телевиз, радио нэвтрүүлэг зэрэг уламжлалт хэвлэл мэдээллүүд агуулгыг ухаалан сэдэх, сурвалжлан найруулах зэрэг талаар элбэг баялаг туршлага ба боловсронгуй дүрэмжлийг хуримтлуулж, шинэ хэвлэл мэдээллээр орлуулж болшгүй давуу талтай болсон юм. Уламжлалт хэвлэл мэдээлэл болон шинэ хэвлэл мэдээлэл нь өөр өөрийн давуу талтай байж, харилцан уусалцаж, сайн талыг нь авч дутагдалтай талаа нөхвөл нийгэмд хамгийн сайн үр нөлөө үзүүлэх нь тодорхой юм.

Уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлчид үзэл бодлоо өөрчлөх нь: Сэтгүүлчийн үзэл санаа ойлголт, сэтгэхүйн арга маяг ба үйл ажиллагааны баримжаа нь цаг үетэй зэрэгцэн урагшлахад нийгмийн хэрэгцээ шаардлагад зохицсон ухамсар ба чадварыг эзэмших учиртай.

Уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлч нь маш сайн үсэг бичгийн үндсэн боловсролтой боловч шинэ хэвлэл мэдээллийн бичвэрийг бэлтгэх арга хэлбэр ба эзэмших мэдлэг чадварын хувьд харьцангуй дутмаг, цаашилбал заримдаа эдгээр шинэ зүйлсээс зайлсхийж, агуулгад нь хэт өөриймсөг ханддаг тал бий. Уламжлалт цаасан хэвлэл мэдээлэл, радио телевизийн хэвлэл мэдээлэл нь мэдээ занги олох гол арга маяг биш болж, одоогийн хэрэглэгчдийн

мэдээ занги олох арга маягтай зохицох хэрэгтэй болсон нь уламжлалт хэвлэл мэдээллийн эрхбиш хийх чухал сонголт мөн гэдгийг мэдрэхгүй байхын аргагүй болжээ. Уламжлалт хэвлэл мэдээллийн найруулан бичих явцад мэдээллийн агуулга нь зөвхөн нэг талын мэдээллийн хувиар уламжлагдаж, мэдээллийн агуулга болон хүлээн авагчдын хоорондох харилцааны үйл явц нь сул, хэрэглэгчид идэвхгүй хүлээн авдаг. Шинэ цаг үед уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлчид уг сэтгэхүйгээ өөрчлөхгүй бол даруй хуучнаа баримталж хэвшмэл, зогсонги байдалд орох болно.

Уламжлалттай харьцуулбал одоогийн хүлээн авагчдын мэдээ зангийг сонгох арга хэлбэр нь нэгэнт олон янз болж, сүлжээ, бичил блог, вичат зэрэгт хүртэл өргөдөж, ялангуяа шинэ хэвлэл мэдээллийн хөгжлийг даган мэдээ зангийн дамжуулга нь нэн шуурхай, нэн дөхөм болж, харилцан нөлөөлөх онцлогоороо давуу байдаг. Хүлээн авагчид иймэрхүү хэвлэл мэдээллийн орчинд мэдээ зангийг хүлээн авах нь олзуурхууштай, яриа хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох явц мөн. Хүлээн авагчид биечлэн оролцох боломжтой учраас идэвх санаачилга нь нь аяндаа нэмэгдэх онцлогтой. Хэвлэл мэдээллийн хувьд иймэрхүү мэдээ зангийн дамжуулга нь амжилттай байж, хэвлэл мэдээллийн цаашдын хөгжилд чухал нөлөө үзүүлэх болно. Иймээс уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлч эн тэргүүнд уг сэтгэхүйгээ өөрчилж, шинэ өрсөлдөөнийг идэвхтэйгээр хүлээн авч, цаг үетэй зэрэгцэн урагшлах нь цаг үеийн шаардлага болж байна.

Шинэ хуучин хэвлэл мэдээллийг харилцан уялдуулах нь: Шинэ хэвлэл мэдээллийн цаг үеийн их урсгалд 2015 оноос эхлэн Дундад улсын хэвлэл

мэдээллийнхэн цаг үеийн шаардлагатай зохицох замыг хайж, хам хэвлэл мэдээллийн тавцанг “Төв тогоон гэр” хэмээн нэрлэж, “нэг л удаад цуглуулж, олон зүйлийг бий болгож, олон эх сурвалжаар дамжуулах” (Цүй, 2019)-ыг хэрэгжүүлж эхэлсэн юм. 2016 онд Дундад улсын “Ардын өдрийн сонин”-ы хорооны “төв тогоон гэр”-ийн тэргүүний мэргэжлээр гол цогцоо болгосон шинэ хэв загвар нь нэгэн нийтлэг жишээ болжээ. Одоогийн Дундад улсад нэгэнт 100 шахам хэвлэл мэдээлэл, байгууллага “төв тогоон гэр” буюу “төв тогоон гэр”-тэй адилхан сурвалжлан найруулах тавцанг байгуулсан байдаг. “Төв тогоон гэр” нь “Ардын өдрийн сонин”-ы хорооны харилцан уялдуулж хөгжихийн суурь тавцан, харилцан уялдуулах бодлогыг эрчимтэй ахиулах хүчирхэг хөдөлгүүр болсон бөгөөд хэвлэл мэдээллийн ажил төрлийн хэлбэрээ хувируулан дэс дэвсхийн амжилттай үлгэр дуурайл болж, “Ардын өдрийн сонин”-ы хороог ерөнхийлсөн бодит хүчнээр хүчирхэг их шинэ маягийн хэвлэл мэдээллийн бүлэглэл болгож, улсын дотоод гадаадын ажил төрлийнхөнд хөтлөн дагуулах, жишээ үзүүлэх үйлдэлтэй болгожээ. Үүнээс үзэхэд уламжлалт хэвлэл мэдээлэл болон шинэ хэвлэл мэдээллийг харилцан уялдуулж хөгжүүлэх нь

хэвлэл мэдээллийн цаашдын хөгжлийн чухал чиг хандлага мөн.

Шинэ мэргэжлийн хөгжил нь уламжлалт сэтгүүлчийн ажилд нь нэн өргөн уудам хөгжлийн шинэ орон зайг нээж өгсөн бөгөөд бас урьд өмнө байгаагүй өрсөлдөөнийг авчирчээ. Фейсбүүк, инстаграм, вичат зэрэг мэдээллийн шинэ сүлжээ эрчимтэй хөгжиж, сонин сэтгүүл, радио нэвтрүүлэг, телевиз зэрэг уламжлалт хэвлэл мэдээллийн оршин тогтнох, хөгжихөд маш их өрсөлдөөн болсон ч ямар нэгэн зүйлийг дамжуулах хэвлэл мэдээлэлд түшиглэж ямар зүйлийг дамжуулах арга барилыг хэрэглэсэн ч уламжилж байгаа нь эцэстээ зөвхөн агуулга байгаа юм. Өвөрмөц агуулга, эрх сүрт агуулгын аль нь ч гэсэн эцсийн зорилгодоо хүрэх зангилаа мөн. Энэ нь мөн ч уламжлалт хэвлэл мэдээллийнх-



Фейсбүүк, инстаграм, вичат зэрэг мэдээллийн шинэ сүлжээ эрчимтэй хөгжиж, сонин сэтгүүл, радио, телевиз зэрэг уламжлалт хэвлэл мэдээллийн оршин тогтнох, хөгжихөд гол өрсөлдөгч болсон ч ямар нэгэн зүйлийг дамжуулах хэвлэл мэдээлэлд түшиглэж, ямар зүйлийг дамжуулах арга барилыг хэрэглэсэн ч уламжилж байгаа нь эцэстээ зөвхөн агуулга байгаа юм. Өвөрмөц агуулга, эрх сүрт агуулгын аль нь ч гэсэн эцсийн зорилгодоо хүрэх зангилаа мөн. Энэ нь мөн ч уламжлалт хэвлэл мэдээллийнхний өөрийн давуу талдаа түшиглэн өөрийгөө шинэчлэх боломж болох юм



ний өөрийн давуу талдаа түшиглэн өөрийгөө шинэчлэх боломж болох юм.

Ямар ч зүйлийг ямагт давуу болон сул тал дагалдаж байдаг. Шинэ хэвлэл мэдээллийн түргэн шуурхай, хамтаар эдлэх онцлогоос шалтгаалж ойрын хэдэн жилд сүлжээ, хэвлэл мэдээллүүдээс худал хуурмаг мэдээ тасралтгүй гарч, зөв бурууг хутгалдуулж байна. 2018 оны Аж үйлдвэр ба мэдээ зангижлын яамны нийтэлсэн “2017 оны

Дундад улсын сүлжээний хэвлэл мэдээллийн олон нийтийн итгүүлэх хүчний байцаалтын мэдүүлэлт”-д тэмдэглэснээр хэрэглэгчдийн сүлжээний хэвлэл мэдээллийн төв чанга чанар, итгэмжийн хэмжээ ба эрх сүрт чанарын тухай ханамжийн хэмжээ тийм ч сайн биш байж, “худал хуурмаг сонин мэдээ”, “зар мэдээ хавчуулах”, “сонин мэдээний хөөрөгдөл” зэрэг үзэгдлүүд нь шинэ хэвлэл мэдээллийн хүнд ноцтой асуудал болжээ (Хөгжлийг судлах төв, 2018). Ийм байдалд уламжлалт хэвлэл мэдээллийн чанга нямбай чанар болон үнэн бодит чанар нь даруй хүлээн авагчдын эрхэм нандин мэдээ зангийн ирэлт ба хүлээлт болдог. Гэвч уламжлалт хэвлэл мэдээллийн уламжлан түгээх арга зам нь даан ч цулгай байж, эл төрлийн хүлээн авагчдын хэрэгцээг хангаж чадахгүй бөгөөд уламжлан түгээх жишсэн зорилгодоо ч хүрч чадахгүй байдаг. Иймээс уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлч нь шинэ хуучныг харилцан уялдуулж, шинэ хэвлэл мэдээллийн уламжлан түгээх шинэ арга барилыг бүтээлчээр зээлэн хэрэглэж, үнэнхүү үнэ цэнтэй бөгөөд чанар сайтай агуулгыг уламжлан түгээх хэрэгтэй юм.

Сэтгүүлчийн мэргэжлийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх нь: Дээд хурдацтай хөгжиж байгаа шинжилгээ мэргэжлийн шинэ цаг үе нь хэвлэл мэдээллийн ажил хийж байгаа сэтгүүлчдийг цаг үеийн онцлогтой зохицсон өргөн дэлгэр мэдлэг мэргэжилтэй байхыг шаарддаг болохоор сэтгүүлчид заавал тухайлсан ажлын тухайн цаг үеийн байдалтайгаа нийцсэн буюу урьдсан дээд түвшний тусгай мэргэжлийн хэв чанартай байх нь чухал юм.

Хэвлэл мэдээллийн ухааны эцэг хэмээгдсэн Уйлбар Шрамм: “Хэвлэл мэдээллийн ухаанд хүмүүсийн бахарх-

лыг хамгаас илүү татдаг нэг зүйл бол мэдээ занги түгээгч ба хүлээн авагч хоёр талынхны тархи толгойд нь зохицонгуй бэлгэдлийг бий болгохын төлөө илгээсэн их хэмжээний мэдээ зангийг сонгон авах ба хасаж хаях явдал болно” гэж дурдсан байдаг. Уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлч нь шинэ хуучин найруулгыг уялдуулсан суурин дээр найруулах явцдаа агуулгаа сайн анхаарч, яс чанарыг батлахаар барахгүй бас шинэ хэвлэл мэдээллийн баазыг боловсронгуй эзэмшиж, хэвлэл мэдээллийн сүлжээний эзэгнэлтийн ур чадварыг эзэмших хэрэгтэй. Шинэ хэвлэл мэдээллийн бааз гэдгийг жишээлбэл, компьютерт ажиллах чадвар зэрэг болно. Фейсбүүк, инстаграм, вичатын нийтийн дугаарыг хэрхэн нийтлэх, аппликейшныг хэрхэн хэрэглэх, эдгээр шинэ хэвлэл мэдээллийн арга барилыг ойлгохоор барахгүй бас боловсронгуй хэрэглэж, өөрөө нэн амар хялбар мэдээ занги олоход дөхөм болгохын хамт сүлжээний үг хэллэгийг боловсронгуй хэрэглэж, хүлээн авагчидтай санал нэгтэй байж, хүлээн авагчдыг татах хүчнийг нэмэгдүүлэн, хүлээн авагчдад хандах харилцаан идэвхжүүлж, уламжлалт хэвлэл мэдээллийн чанар сайтай агуулгыг уран дэмтэй уламжлан дамжуулах нь чухал болж байна.

Сэтгүүлч нар мэдээ зангийг хянах үүрэг, хариуцлагыг ухамсарлаж, мэдээ зангийг хянахаар дамжуулан, уламжлан түгээх чухал ач холбогдолтой мэдээ зангийг сонгон авч дамжуулан түгээнэ. Уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлчид шинэ мэргэжлийн арга барилыг сонгон хэрэглэхдээ шинэ зууч нь агуулгын уламжлалд зохицох эсэхийг заавал тодорхой мэдэх хэрэгтэй. Үүний хамт сэтгүүлч хүний хувьд нийтлэл, нэвтрүүлгийн агуулгыг шинэ хэвлэл

мэдээллийн хэлбэр маягт зохицуулахад эрхбиш хэвлэл мэдээллийн агуулгыг найруулан жагсаах, зурж төлөвлөх ба зохиохдоо чадамгай байж, уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлч өөрийгөө цаг үетэйгээ зохицуулан хөгжих шинэ шаардлагыг биелүүлэх учиртай юм.

Дүгнэвэл, уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлчид цаг үеийн хөгжлийн хандлагатай зохицож, шинэ хэвлэл мэдээлэлтэй зэрэгцэн урагшлахад шинэ хуучин хэвлэл мэдээллийн тус тусын онцлог шинжийг гүйцэд таньж авах, бас уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлчид хэвшмэл хуучин үзэл санаагаа шинэчлээд, шинэ хуучин хэвлэл мэдээллийг оновчтой харилцан уялдуулж, сэтгүүлчийн мэргэжлийн мэдлэг боловсролоо цаг ямагт дээшлүүлэх хэрэгтэй юм.

Эшлэл

1. Дундад улсын интер сүлжээний мэдээ зангийн төв. 2022 он. 49 дүгээр удааны “Дундад улсын интер сүлжээний хөгжилтийн байдлын бүртгэлийн мэдүүлэлт”. <http://www.cnnic.net.cn> (中国互联网络信息中心：第49次《中国互联网络发展状况统计报告》·2022).
2. Дуван хон жяо. 2019. Шинэ зуучлуурын цаг үедэх тэмдгийн хөгжилтийн хандлага. <https://www.wenmi.com/article/pvlwbo04ehak.html> (段红娇：浅析新媒体时代下标志发展新趋势，2019).
3. Цүй ши шин. 2019. “Төв тогоон гэр”-ийн чадамжийг гүйцэд бадруулж хам зуучлуурын “нэг цогцжуулах” бүтээн байгуулалтыг ахиулах хэрэгтэй. http://www.81.cn/jsjz/2019-06/28/content_9542040.htm (崔士鑫：充分发挥“中央厨房”功能 促进全媒体“一体化”建设，2019).
4. Улсын аж үйлдвэрийн мэдээ зангийн амар түвшний хөгжилтийг судлах төв.

2018. 2017 оны дундад улсын сүлжээний зуучлуурын олон нийтийн итгүүлэх хүчний байцаалтын мэдүүлэлт. <https://baijiahao.baidu.com> (国家工业信息安全发展研究中心：2017年中国网络媒体公信力调查报告，2018).

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Брайн С. Брукс, Жек З. Сисос, 2013. Редакторын урлаг. БНХАУ - ын Рэньмин их сургууль.
2. Би Шүчин, Ли Тинтин. 2017. Харилцаа холбооны өөрчлөлт-шинэ эриний уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрчлөлт хөгжил. Жянсу мужийн шинжлэх ухаан технологийн хэвлэл. (毕书清、李婷婷：《传播变革——新时期传统媒体的变革与发展》·江苏科学技术出版社)
3. Дуван хон жяо. 2019. Шинэ зуучлуурын цаг үедэх тэмдгийн хөгжилтийн хандлага. <https://www.wenmi.com/article/pvlwbo04ehak.html> (段红娇：浅析新媒体时代下标志发展新趋势·2019).
4. Дундад улсын интер сүлжээний мэдээ зангийн төв. 2022 он. 49 дүгээр удааны “Дундад улсын интер сүлжээний хөгжилтийн байдлын бүртгэлийн мэдүүлэлт”. <http://www.cnnic.net.cn> (中国互联网络信息中心：第49次《中国互联网络发展状况统计报告》·2022).
5. Жөү Вэйшянь., Чэнь Баолянь. 2017. Бүтээлч сэтгэхүй, төлөвлөхөөс хүний хоорондын харилцаа. Бээжингийн хамтарсан хэвлэл. (鹭尾贤也 (作者)，陈宝莲 (译者)：《编辑力：从创意、策划到人际关系》·北京联合出版公司)
6. Мэн юй. 2014. Юй шиян шөн кев: сүлжээний үг хэлэх эрхийн үйлдлийн хэлбэр. <https://wenku.baidu.com/view/15191b3c17791711cc7931b765ce05087632>

7564.html (孟宇、俞香顺口：网络话语权的作用形式.

7. Отгонбаяр. 2018. Монгол үндэстний уламжлалт соёл. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэл.
8. Улсын аж үйлдвэрийн мэдээ зангийн амар түвшний хөгжилтийг судлах төв. 2018. 2017 оны дундад улсын сүлжээний зуучлуурын олон нийтийн итгүүлэх хүчний байцаалтын мэдүүлэлт.
9. Цүй ши шин. 2019. “Төв тогоон гэр”-ийн чадамжийг гүйцэд бадруулж хам зуучлуурын “нэг цогцжуулах” бүтээн байгуулалтыг ахиулах нь.

http://www.81.cn/jsjz/2019-06/28/content_9542040.htm (崔士鑫：充分发挥“中央厨房”功能 促进全媒体“一体化”建设.

Summary

This paper discusses the development trend of new media, analyzes the advantages of new and old media, problems and opportunities faced by traditional media editors in the new media era, and puts forward effective ways to realize the self transformation of traditional media editors.